



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/543

Алтай хот


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 31 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээ тогтоолгон, дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн Орон нутгийн өмчийн газрын хөрөнгөд бүртгэлтэй хуучин граж агуулахын барилгыг гэрээний дагуу хөрөнгийн үнэлгээ хийсэн ажлын зардал 3,920,000 (гурван сая есөн зуун хорин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР